

Томас Саржент ба Кристофер Симс нар Нобелийн шагнал хүртлээ

2011 оны 10 дугаар сарын 10-нд Шведийн Эзэн хааны ШУА-с эдийн засгийн шинжлэх ухаанаар Нобелийн шагнал хүртэх эрдэмтдийн нэрсийг зарлалаа. Энэхүү шагналыг АНУ-ын Томас Саржент болон Кристофер Симс нар “макро эдийн засаг дахь шалтгаан, үр дагаврын эмпирик судалгаа”-г хийж гүйцэтгэсний төлөө авсан байна.

Эмпирик судалгаа гэдэг нь юмс үзэгдлийг танин мэдэх өнө эртний арга хэлбэр бөгөөд энгийн ажиглалт дээр суурилдгаараа онцлог юм.

Дайны дараахь он жилүүдэд улс орнууд эдийн засгийн өсөлтийг урьтал болгон инфляци хөөрөгдөөд эцэс сүүлд нь эргээд үнийн өсөлтөө тогтворжуулахад анхаарч ирснийг Нью-Йоркийн их сургуулийн Томас Саржент судалсан байна. Энэ үед өрхийн аж ахуй, хувийн сектор, том бизнесийн үйл хөдлөл хэрхэн өөрчлөгдөж байсныг профессор Саржент судалгааныхаа сэдэв болгожээ.

Нэг талаас Төв банкны хүү инфляци, эдийн засагт хэрхэн нөлөөлсөн, нөгөө талаас засгийн газар, сангийн яамны шийдвэрүүд хөрөнгө оруулалт, ажилгүйдэл, ДНБ-нд хэрхэн нөлөөлж ирснийг Принстоны их сургуулийн Кристофер Симс судалсан байна.

Томас Саржент болон Кристофер Симс нар харилцан хамааралгүй ажиллаж байсан ч тэдний 1970-1980-аад хийж гүйцэтгэсэн бүтээлүүд нь нэг нэгийгээ нөхсөн шинжтэй байсан байна.

Саржент, Симс нарын санал болгосон аргуудыг өнөөгийн улс төрчид, эдийн засагчид өргөнөөр ашигладаг байна. Саржент, Симс нарын бүтээл нь улс төр болон эдийн засгийн харилцан хамаарал, үйлчлэлийг олж тогтоосноороо ихээхэн онцлог болсон байна.